

МОНГОЛ АМАН ЗОХИОЛ ДАХЬ ШИДЭТ ЗҮҮДНИЙ ДҮР, ӨГҮҮЛЭМЖ

И.Даваадорж

Хураангуй: Монгол аман зохиолын төрөл зүйлсэд хүний оюун санааны нэгэн тал тусгал болсон зүүдийг ялгаатай байдлаар дүрслэн илэрхийлсэн байдаг. Бид уг өгүүлэлдээ тодорхой явдал өгүүлэмж бүхий аман яруу найргийн зүйл болох тууль, хүүрнэн өгүүлэх аман зохиолд багтах үлгэр, түүх домогт буй шидэт зүүдний өгүүлэмж, элдэв хатуу дутууг бүтэн болгогч баатрыг шинжлэн үзлээ. Ийн үзэхэд зүүдэнд өрнөх алив үйлийг хөтлөх баатар болох Цагаан өвгөн, Балданлхам бурхны үйл нь сэрсэн төдийд биелэх зайлшгүй төлөвтэй, зүүд болон бодит байдлыг холбосон шалтгаан үрийн холбоотой илтгэж байна.

Түлхүүр үг: *Шидэт зүүд, Балданлхам, Цагаан өвгөн, бодитжсин биелэх өгүүлэмж, тууль, үлгэр, түүх домог*

Аман зохиолын төрөл зүйлсэд зөнтэй зүүдний өгүүлэмжийг илтгэхээс гадна хийсвэрлэх арга, сэтгэлгээний илэрхийлэл болсон шидэт шинжийг агуулдаг. Баатарлаг тууль, шидэт үлгэр зэрэг аман зохиолын төрөл зүйлсэд зүүдэнд шид эргэн дутуу хатууг нөхөх болон эрдэм чадалт баатар харь бусдад зүүд өгч өөрийн хэргийг бүтээх шидэт өгүүлэмж илэрч байна. Шидэт зүүднээ ирэх монгол соёл болон Бурханы шашинд хамаарах баатрын үйл нь сэрсэн төдийд биелэн биежиж, зүүд хэмээх ухамсарт болон ухамсаргүй сэтгэл оюуны зүйл болон бодит байдлын хил заагийг бүдгэрүүлж, зүүд зөн болон хүртэгдэх физик ертөнцийн явдлыг шалтгаан үрийн холбоотой болгож байна.

Дээр дурдсан зүүдэнд үзсэн зүйл сэрсэн даруйд бодит болж, шид эргэх өгүүлэмж *Наран хаан* хүү урианхай туульд буй юм. Туулийн баатар Хонгор шар хүү Хүдэр арслан цээжтэй тулалдаж байгаад, амийг нь тэвчихийн цагт ах дүү болохыг гуйдаг. Хүдэн арслан цээж анд барилцахын өмнө өөрийн түүх намтар, уг язгуураа тоолон хэлдэг.

*Доод замби тивийн
Довон хар бөх аавтай
Дээд хаан хурмастын
Зүүдэн солонго дагина ээжтэй...
Зүүдэн солонго дагина
Дунд замба тивд
Орж ирээд
Наран хаан хүүгийн
Нарийхан гүрмэл хар
Уулын алтан агуйд
Нимбэ цамба бүтээж байхад
...Довон хар бөх
Зүүдэн солонго дагинатай
Алтан агуйд
Уулзан танилцаж
Хүсэл жаргалаа хангаж зүүдэллээ
Зүүдэн солонго дагиныг*

Зүүдэлж хоносон шөнө

Чи заяаж төрсөн учиртай билээ л (НТЧТ, 2010: 403-404).

Уг хэсэгт хатгалдагч дайсан Хүдэр шар баатрын ээж Зүүдэн солонго дагина дунд тивийн агуйд бүтээл нямба хийж бүхүйд доод тивийн Довон хар бөх танилцан, хүсэл жаргалаа эдлэн зүүдлээд сэрэхэд баатар төрсөн тухай өгүүлжээ. Энэхүү өгүүлэмж нь зүүднээ үзсэн зүйл төдий дор бодитжин биелдэг шидэт зүүдний шинж юм. Мөн анд барилдахаас өмнө уг түүх, учир хэргийг хэлэх сонирхолтой өгүүлэмж гарч, түүний хойно “Эгэм далаа түшилцээд, Эрхий хомхойнхоо цус хөхөлцөөд”(Мөн тэнд: 405), мэс сэлмийн ир долоож буй нь “...андын холбоог тогтоосон төдийгүй нэгэнт тогтож асан хэлхээг ахин сэргээсний бэлгэдэл, андгайг дахин няцвал цус гарган үхүүлэгтүн гэсний баталгаа байжээ” (Цэдэв, 1998: 77).

Зүүд хүртэгдэх бодит байдалд урван хувирах шидэт өгүүлэмж ёр билгийн шинжтэй доорх үлгэрт туссан байдаг.

Эртийн цагт нэг сайхан охин өвгөн буурал ажсаа, эмгэн ээжтэйгээ амьдран суудаг байв. Хөгшин ээж нь охиндоо томоо бүтэн сартай шөнө өрхөө татаж унтаарай гэж захидаг санж. Нэг дүүрэн сартай шөнө охин өрхөө таталгүй унтаад, ээж аав нь хол газар одож, хоттой мал нь хуйгаараа үхээд, өөрийгөө эмгэн болсон байна гэж зүүдэлжээ. Тэр хар даран ухаан зумгүй сэрэхэд, өөрийгөө харахнаа эмгэн болсон байжээ.¹

Уг үлгэрт эхийн захидаг цээрийг мартсанаар түүний хоруу чанарт үр гарч буйг зүүдний шидэт өгүүлэмжээр дамжуулан илэрхийлжээ. Мөн энэхүү өгүүлэмж нь сар дэлхийн соронзон орон, далайн түрлэг зэрэгт нөлөөлдөг, үехэн унтах (*REM sleep*) үеийн хугацааг ихэсгэж хүнийг тавгүйтүүлдэг гэх байгалийн шинжлэх ухааны үндэслэл онолтой таацаж байна.

Зүүдэнд үзсэн зүйл даруй биелэх шидтэй зүүдний уг шинж тариачны нутгийн Өнчин Бүш хүү Түс Годилын шидэт үлгэрт тодорхой харагддаг. Өнчин Бүш хүү аяганы чинээ нууртаа атга чихэр хутгаад, гурван зуун арван хоёр шувуу жигүүртэн агнаад хаанд бараалхдаг. Эл үлгэрийн баатар ижил хань, сүйт хүнээр дутсан нь үйл явдлыг эхлэн өрнүүлэх зангилаа болох бөгөөд ихэс дээдсийн охинтой суухаар санаархсан өнчин Бүш хүүгийн нэг нүд, нэг гар, нэг хөлийг таслан авч, цагаан талд хаяж орхидог.

Үхэхэд шадартаж байхад зүүдэнд нь нэг цал буурал цагаан сахалтай өвгөн цагаан мөнгөн таяг гартаа барьж ирээд “Хөвгүүн амаа ангай” гэв... өвгөн аманд нь нулимж орхиод, цээжээр нь цагаан мөнгөн таягаараа хоёр гурав цохиод “За хөвгүүн, хөл гар нүд чинь эдгэх. Мууд үзсэн хүнийгээ “наалданхай” гээ, сайнд үзсэн хүнийгээ “бусраад” гээ гэж хэлээд явж одсон болж зүүдэнд нь мэдэгдсэн даруй, сэрэхнээ нь хөл гар нүд нь цугаар ургаад байжээ (МАУ, 1982: 94).

Уг хэсгийг ажиглан үзвэл үхэл амьдралын голд шадартаж буй баатарт туслагч баатар зүүднээ үзэгдэн, эд эрхтний дутууг нөхөж, дайсан этгээдийг дарах, сайн нөхрийг шагнах үгийг заан одож байна. Оюун санааны хий хийсгэлэн төлөвтэй зүүд нойрны үед цагаан өвгөн үзэгдэж, тастаж орхисон гар, хөл, нүдийг эргүүлэн жир болгож буй нь зүүднээ шид эргэх шидэт өгүүлэмж юм.

Өнчин Бүшийн зүүднээ үзэгдэх цагаан өвгөнийг үлгэрт гүйцэтгэж буй үүргийн талаас судлаач Б.Дайриймаа “Монгол ардын үлгэрт буруугүй, шударга бусаар шийтгэгдэн хөөгдсөн тэдний гайхамшигт аврагдлын мотив” мөн бөгөөд үлгэрт “шидэт туслагчийн хувиар дүрслэгдэнэ” (2013: 50-51) гэсэн байна. Г.Нандинбилиг, С.Дулам нар дэлхийн эзэн Цагаан өвгөн сахиус, цагаан зүгийн бөө нарын уг гарвал “ид шидийг бэлэглэн соёрхогч” (2020: 143) баатар хэмээжээ.

Цал буурал цагаан сахалтай, цагаан мөнгөн таягтай өвгөн нь буддын болон түүнээс өмнөх үеийн домог зүйн дүр бөгөөд “...домгийн дүрүүд үлгэрт шилжсэний нэг жишээ байж болох юм”

¹ Архангай аймгийн Өгийнуур сумын харьяат өөлд овогтой Бямбасүрэнгийн Даваасүрэнгээс 2021 оны 7-сарын 18-ны өдөр Архангай аймгийн Өгийнуур сумын төв Зэгстэй багт И.Даваадорж тэмдэглэн авав.

(Дайриймаа, 2017, 56). Монгол утга, соёл дахь цагаан өвгөн нь “...мал сүргийн эзэн болохоос гадна газар дэлхийн үр шимийн эзэн болдог” (Дулам, 2020 [1989]: 281). Монголчуудын адгуулан аж ахуйдаа ашигладаг таван хошуу мал өсөх, хорогдох нь ганц маллагаа, газрын гарцаас бус хүнд үл хүртэгдэн мэдрэгдэх тэнгэр нэрээс ч хамаардаг.

Цагаан өвгөн нь хишиг буянаа хайрладаг ч мөн догшин дүрийг үзүүлж, мялзан, ордосчуудын хувьд цохилуур зэрэг өвчнийг тархаадаг “...Мялзангийн цагаан өвгөн гэж нэрлэдэг бололтой” (Дулам, 2020 [1989]: 281). Энэ талаар Антоон Мостаэрт ордос монголчуудын дунд дэлгэрсэн Цагаан өвгөний шүтлэгийг сурвалжлан тэмдэглээд “... Цагаан өвгөнийг зөвхөн хүндэтгэл бишрэл талархлаар бус айж эмээснээсээ шүтдэг нь түүнийг хишиг буянаа хайрладаг ч заримдаа догширдог гэж итгэдэгтэй холбоотой аж” (Мостаэрт, 2011: 151) хэмээжээ. Эндээс ажвал уг дүр нь хайр ивээл хайрлагч болон халдан догширогч хоймсон шинжтэйг ажиж болно.

Бөө мөргөлөөс үүтгэл бүхий энэхүү домог зүйн дүр нь буддын шашинд цагаан өмсгөл, зүүсгэлийг зүүж дүрсэлж, “...таяг тулж, хулуу үүрэн, буга унаж, тогоруу дагуулсан өвгөнөөр зурдаг. Үүнийг чинагшлаад буян, эд, нас, үр дөрвийг хамарсан бурхан болгож тахидаг” (Дулам, 2020 [1989]: 282) ажээ. Цагаан өвгөний санд “...эд малын гарз, мал сувайрах, сүү цагаан идээний хэсгийг арвижуулж, санасан бүгдийг бүтээхэд их тустай” (Чоймаа II, 2015: 471) хэмээн тэмдэглэснээс ажвал, бөө мөргөл дэх Заяагач тэнгэр, Цагаан өвгөний адгуулан хариулдаг малын хишиг буянтай холбон үздэг ойлголт Бурханы шашнаа хувиран нийлэгжсэн хэмээн үзэж болохоор байна.

Цагаан өвгөн Их хүрээний Жахар цамд Энэтхэг орноос ном номнохоор ирсэн хоёр азраар түшүүлэн гарч ирдэг нь “...буддын шашинд багтах, эрдэмт багш нар бурхдыг залан авчрахыг бэлгэддэг. Мөн Цагаан өвгөний зүүн гартаа луу тэргүүнтэй таяг, баруун гартаа эрих тус тус барьж, “Шашныг өөд мандуулна” хэмээн баруун хөлөө дээш өргөсөн, “муу бүхнийг дарагч” хэмээн зүүн хөлөө доош дарсан байдаг” (Лхагвадолгор, 2011: 57). Бөө мөргөлөөс үүтгэл бүхий уг домог зүйн дүр хишиг буянтай холбогдох, шашин дэлгэрэн тэрсүүдийг дарах утгыг давхар илэрхийлж буйг цам бүжгийн даяг дэгээс харж болох юм.

Цагаан өвгөний өгүүлэмж нь зүүдний шинжийн сударт тайлбартай нийцэх бөгөөд Цагаан сахалт өтгөс гэрт орон зүүдэлбэл “... буян хишиг, хутаг нэмэх, аливаа үйлс бүтэх, настай сайн” (Дулам IV, 2020: 60) хэмээх аж.

Бөө мөргөл болон Бурханы шашны нийлэг шинжтэй Цагаан өвгөнийг зүүднээ үзэж, шид эргэснээр дутагдал гачаал, өстөн хорон санаатны учруулсан хохирлоос салж буй шидэт өгүүлэмж газар усны түүх домог болон түүхэн домогт цөөнгүй байна. Увс аймгийн Давст сумын нутаг Цахиурт хэмээх газрын талаар нэгэн түүх домог буй. Нэгэн малчин хонио хариулж яваад нэг толгой дээр тамхи татахаар завдсан ч хэтээ хайгаад олдоггүй. Тэр зуур малчин түр зүүрмэглэн, зүүдэлдэг.

Нэг цагаан хувцастай өвгөн ирж:

Дэргэд чинь бөөн цахиур байхад

Дэмий юундаа гансарна вэ?

Цаана чинь бөөн цахиур байхад

Цагираглаад (Цагариглаад И.Д) хэвтэх чинь юу вэ? (ДАЗЧ, 2017: 325) хэмээдэг.

Малчин зүүднээс сэрэн ажихад галт цахиур газар сайгүй болсон тул тэр газрыг тэр цагаас хойш Цахиурт гэж нэрлэсэн болжээ. Уг түүх домгийг ажин үзвэл, дутуу дулимаг зүйлийг нөхөн өгөгч туслагч баатар нь шидэт үлгэрт буй туслагч баатартай нэгэн ижил янзаар дүрслэгдэх цагаан хувцастай өвгөн байна. Мөн малчин цахиур чулуу хайж байгаад унтсаны хойно зүүднээ шид эргэж, газар сайгүй гал асаах чулуутай болсон нь Өнчин Бүшхүү, түс годилын үлгэрийн өгүүлэмж болон үзэгдэх дүртэй таацаж байна.

Монгол түүх домогт газар усны тогтоц байц, нэрийн учрыг тайлбарлах гурван үндсэн хэв шинж байдгийн “... өндөр насыг насалсан эмгэн өвгөн юм уу эгэл жирийн хүний аж байдалтай холбон тайлбарлах” (Нандинбилиг, Дулам, 2020: 212) нэгэн шинж уг түүх домогт мөн илэрчээ.

Үүний ижил зүүдлэн нойрсож байх хооронд газар орны байц өөрчлөгдөн хувьссан өгүүлэмж *Гурван тэсийн давс* гэх түүх домогт бий. Уг түүх домогт туйлын ядуу хүү гуилгачлан яваад хавтгай унасан хүнтэй таардаг. Хүү эд гуйж, өглөг хүсэхэд өврөөсөө олон түлхүүр гаргаж ирээд нэгийг нь ав хэмээдэг. Хүү содон харагдсан түлхүүрийг авдаг.

Нөгөө хүн “За наад түлхүүрээ дэрлээд унтаарай” гээд нар шингэх зүг яваад өгчээ. Хүү түлхүүрээ дэрлээд хэвтэж байтал нар шингэх зүг яваад өгчээ. Хүү түлхүүрээ дэрлээд хэвтэж байтал таг унтчихжээ. Сэрээд хараад эргэн тойронд нь сүм суварга шиг давс ургасан байжээ. Ингээд Гурван тэсийн давс бий болсон юм гэдэг (МДЧ, 1999: 372).

Бүс болон оймс дэрлэн зүүд манах, сувьх ёсны тусгал бүхий уг түүх домогт үйл явдлыг хөтлөх гол баатрыг унтаж нойрссоны удаагаар газрын байц өөрчлөгдөн давстай болсон тухай өгүүлж буй. Энэ нь өмнөх түүх домогт зүүдэлж бүхүйд шид эргэн гачигдал дутагдал гүйцэж буй өгүүлэмжтэй ижил байна. Мөн зэрлэг амьтан болох хавтгай унасан туслагч баатар түлхүүр өгөх нь ядмаг дутуу амьдралаас эд баялаг нээх бэлгэдэлт утгыг агуулжээ.

Зүүдэлж бүхүйд туслагч баатар болох Цагаан өвгөн үзэгдэж, дутагдал гачаал арилж буй шинжээс гадна зүүднээ үзэгдэх уг баатар нь хатуу сануулга, ялагдлын хэл мэдээг сануулан дохиолдог тухй *Тогоонтөмөр, Ананд Мадхи хоёрын тангараг тасарсан домог*-т өгүүлдэг.

Тогоонтөмөр хаан нэгэн шөнө хар даран зүүдэлрүүн, Цал буурал өвгөн орж ирээд: - Чи хоточ нохойгоо тэвчлээ. Одоо гадаадын довтлогч чоно ирж явна. Түүнийг чи юун хэмээн сэтгэнэ гэж хилэнтэй хэлээд алга болжээ. Тогоонтөмөр сэрмэгц айж өөрийн нохой гэсэн нь Тогтохыг алсан минь болов уу. Гадаадын чоно гэсэн нь Югэ ноён удсаных болов уу гэж бодоод тэр шөнө нойр нь хүрсэнгүй (МДЧ, 1999: 53).

Тогоонтөмөр (1333-1370) хаан маргааш нь Ананд Мадигаас зүүдний учрыг лавлахад “нохой мэт Тогтох тайшийг тэвчин, довтлогч чоно мэт Югээг итгэснээс гэм болохын урьд отлогын зүүд нь энэ буюу” (Мөн тэнд) хэмээдэг. Их Юань гүрний уналттай холбогдох түүхэн хүний тухай уг түүх домогт Цагаан өвгөн нь буруу хэрэг үйлдсэнийг мэдүүлэх, угтан ирэх унал бутралыг сануулан мэдүүлж байна.

Үлгэр, түүх домогт дурдагдаж буй туслагч баатар Цагаан өвгөн нь Монгол дахь Бурханы шашны III дахь дэлгэрэлттэй холбоотойгоор ядам, чойжин бурхад, номын ханд дагина болон хувирч, Бурханы шашны хууч яриа, аман түүхэд их зонхи тусгалаа олсон байна. *Лхамын шавгийг шүтсэн нь* хэмээх хууч домогт ноёны хойноос хүрээг зорин явж байсан хатан муур лүгээ амьтанд дайрагдан ухаан самуурдаг. Ийн даасан багшаас эдгэх арга асуухад Лхамын шаваг хэмээх номыг өдөр бүр уншиж бай хэмээдэг.

Нэг жилийн дараа цагаан сарын битүүний шөнө мөнөөх хатан зүүдэлжээ... нэгэн хул морь унасан эмэгтэй хүн давхиж ирээд хатныг дайраад баруун хойшоо давхиж гэнэ ээ. Тэгж дайрахдаа тэр мориных нь өрөөсөн хөл зүүн дал дээр нь гишгээд гарлаа гэж зүүдэлжээ. Тэгээд сэрсэн чинь зүүн далных нь тэнд хөндүүр болсон байсан бөгөөд хэд хоног тэр газар нь хавдаж байгаад хагараад мөнөөх хатны солио өвчин нь бүрэн эдгэрчээ (МБШАТ I, 2021: 57).

Нэгэн хул морь унасан эмэгтэй хүнд дайрагдан, зүүн мөрөндөө гишгүүлэн зүүдлэх, сэрсний хойно зүүднээ морь гишгэсэн газар хөндүүр орж, улмаар хатны солио өвчин арилах энэхүү өгүүлэмж нь зүүднээ шид эргэн бодит болох өмнөх жишээ нэртэй адил шинж буй юм.

Тухайн өгүүлэгч гуравдугаар биеэс үйл явдлыг тоочих хууч домогт Бурханы шашны арван хангал сахиусны нэг *Балданлхам*² бурхныг дүр болгожээ. Уг шидэт зүүдний өгүүлэмж бүхий

² Балданлхам (sans. *Śrīdevī*, мон. Цогт охин тэнгэр). Арван хангал бурхны чойжин бурхдын нэг. Балданлхам бурхан нь Янжинлхам бурхны хилэнт дүр төдийгүй, Сайн цагийн мянган бурхны шашин бүрийг хамгаалах ам тангараг өргөсөн чойжин бурхан юм. Урлан бүтээх дэг буюу илт онолд хязгааргүй огторгуйд оволзон бялхалзах нүгэлтний цусан их далайн байх бөгөөд хар их салхин дунд шар халзан луус унах, нэг тэргүүн, цахилгаан мэт гялбалзах гурван улаан мэлмийтэй бөгөөд амаа ангайн хүүр зууж, их дууг гарган хашхирдаг хэмээжээ. Балданлхам бурхан нь хоёр өлмийгөөр газар дэвслэхэд гурван ертөнц доргих, ха ха инээхэд Сүмбэр уул хотолзох

хууч домгийн үйл явдал өрнөх гол цаг нь цагаан сарын битүүний орой буюу Балданлхам бурхан ертөнцийг тойрон, хүн зоньг эргэдэг хэмээх цаг байна. Мөн солио өвчтэй хатны зүүдэнд хул морь унасан эмэгтэй хүн үзэгддэг нь рид хувилгааны хөлтэй, хийн жигүүртэй, түргэн одохуйн эрдэмтэй унаа хөлөг болох хонгор халзан луусын зүсийг хувирган тоочсон хэлбэр байна.

Төгс гэгээрэл хүрэхээс өмнөх шатыг хамгаалагч Чойжин сахиус Балданлхам бурхныг анагаах шид бүхий хууч домогт өгүүлэх нь Цогт охин тэнгэрийн олон шид тустай холбоотой юм. Балданлхам бурхан нь “... Гучин гурван тэнгэрийн орноо Мүлүдэнгийн их далайд галбарваасан мод шүтэж эмч охин тэнгэрийн дүрсэнд оршдог” (Баясгалан, 2012: 330-331) бөгөөд Цогт охин тэнгэрийн шашныг хамгаалагч арван хоёр дагина дотор их эмч байдлаар үзэгдэгч (зарим тохиолдолд мамо байдлаар оршигч) Төвөд орныг сахигч эх, Ганц эмч эх, Зээлийг сэрүүтгэгч эх, Сайн өнгөт эх дөрөв багтдаг. Эдгээрээс үзвэл Цогт охин тэнгэр нь анагаах үйлтэй холбогдох бөгөөд шидэт зүүдний өгүүлэмж бүхий хууч домогт Балданлхам бурхны энэхүү эрдэм чадлыг зүүднээ моринд дайруулаад боссон төдийд эрүүлжин тунгалагшиж буйгаар үзүүлжээ.

Дээрх санааг Балданлхам бурханы адисаар өвчнөөс гэтэлсэн нь гэх хууч домгоор баталж болно. Нэгэн хувилгаан лам 13 нас хүрч жил ороод, салхин цэцэг өвчин тусдаг.

...өвдөж бие чилээрхэхдээ Балданлхам бурханд залбирсанд зүүдэнд нь “Луус хөлөглөсөн, догшин хар царайтай нэгэн дагина эмэгтэй хүрч ирээд ташуураараа түүнийг хэд дахин ташуурдаж байна” хэмээн зүүдэлсэн бөгөөд түүнээс удалгүй тэрхүү ламын өвчин нь илаарышиж зүгээр болсон гэдэг (МБШАТ II, 2012: 100).

Дээрх хууч домогт өмнөхийн адил Балданлхам бурхан зүүднээ үзэгдэж, залбиран аврал одуулсан хүний биед хүрч (дайрах, ороолгох), өвчин эмгэгийг эдгээж буй өгүүлэмж илэрч байна. Энэхүү өгүүлэмж нь зүүдлэн сэрсний удаагаар эд эрхтний элдэв дутуу эдгэн илаарышиж буй шидэт үлгэрийн шинж хууч домогт уламжлан ирснийг харуулах бөгөөд туслагч баатар Цагаан өвгөн нь аврал одуулсан бүгдэд тусыг хүргэх арван хангал бурхны нэг Цогт охин тэнгэр Балданлхам болжээ.

Монгол орноо “...цагаан сарын баяр ёслолыг бүх тохиолдолд Лхам бурхантай холбон үздэг нь монгол ёс заншил, бурхан шашны домог хоёрын нийлэг (синкретизм) болсон өвөрмөц домгийг буй болгожээ” (Нандинбилиг, Дулам, 2020: 112). Балданлхам бурхан цагаан сарын баяртай холбогдох өгүүлэмжийг говийн халхчуудын дунд яригддаг цагаан идээний бэлгэдлийн домог, Шинжааны ойрад торгуудын савардан бүжгийн домог, бузаав торгуудын “Цагаан” гэх дууны домог, “Галбын үлгэр”-ийн Сам бурханы домгоос харж болно.³ Цагаан сарын битүүний орой Цогт охин тэнгэрийн унаа хүлэг болох луусыг ундаална хэмээн тогто зэрэгтээ мөс тавих, хатавч газраа харгана хавчуулдаг ёс бий. Уг зан датхалын зүйл нь Цагаан өвгөн болон Балданлхам бурхны холбоо хамаарлын тухай авч үзэх нэгэн тал боломжийг үүсгэж байна.

Алтай урианхайчуудын хишиг буяны эзэн Цагаан өвгөнд зориулан үйлддэг ёс Бурханы шашны нөлөөгөөр Балданлхам бурханд болж өөрчлөгдсөн гэх санааг удаах угсаатны зүйн мэдээ баримтаар нотолж болно.

Цагаан өндөр Алтайн уулсын хамгийн өндөр газар цас мөсний оронд уулын эзэн “Цагаан өвгөн” амьдардаг ажээ. Тэр байгаль дэлхийг баян тансаг байлгаж, хүн ардыг эрүүл энх жаргал цэнгэлээр дүүрэн байлгахын төлөө бүхнийгээ зориулдаг юм. Битүүг хагарах өдөр цагаан өвгөн уулнаасаа бууж ард зоньхоо гэр орноор айлчилдаг тул түүнийг гэртээ урин залахаар мөсөн зам засаж, урт цагаан таягийг нь бэлгэдэн бургасан саваа хавчуулдаг (МУУЗ II, 2012 [1996]: 397).

Уг угсаатны зүйн мэдээ баримтаас харвал битүү хагалах, битүүлэхэд Цагаан өвгөн айл бүрд ирдэг учир орох замыг засан мөс тавих, тул таягийг бэлтгэн бэлгэдэж бургасан саваа

чадалт охин тэнгэр юм. Энэхүү бурхан нь даатгасан бүхний л үйлс явдлыг бүтээх бөгөөд цагаан сарын битүүний шөнө гурван ертөнцийг тойрдог хэмээн үзэж мөс тэргүүтэн зүйлсийг хаалга, тогто хавьд тавих уламжлал буй (Баясгалан, 2012: 305-380 талаас үзнэ үү).

³ Нандинбилиг, Г., Дулам, С. (2020). *Монгол аман зохиолын онол II (Хүүрнэн өгүүлэх аман зохиол, Жүжиг наадмын аман зохиол)*. Улаанбаатар: МУИС Пресс. 107-112 хуудсыг үзнэ үү.

тавьсан нь Балданлхам бурхны хөлөглөн явдаг хонгор халзан луусыг ундаалах идээ болгон мөс бэлтгэн тавих үйлтэй хоймсон давхцаж байна. Шидэт үлгэр, түүх домогт баатрын зүүднээ үзэгдэх туслагч баатрыг Цагаан өвгөн, Балданлхам бурхнаар төлөөлүүлэн үзэх нь тохиолын хэрэг бус хишиг буяныг өгөх тэнгэр, тусыг түргэн бүтээх чойжин сахиусан тодорхой холбоог харгалзан үзсэн хэрэг хэмээн үзэж болох юм.

Шидэт зүүдний эдгээр өгүүлэмжээс ажин үзвэл, зүүдэнд үзэгдэн элдэв гачаалыг ханган, өвчин эмгэгийг илаарьшуулах баатар нь шашин, соёлын утга үүрэг бүхий Цагаан өвгөн, Балданлхам бурхан байна. Зүүдний өгүүлэмжид эдгээр баатрыг ашигласнаар зүүд гэх хийсвэр байдал болон хүртэгдэх бодит байдлын хил хязгаарыг давж, зүүд болон бодит амьдралд болох үйл явдлыг шалтгаан үрийн холбоогоор хэлхэх боломжтой болжээ.

Дүгнэлт

Монгол аман зохиолын төрөл зүйлсэд хүний ухамсарт болон ухамсаргүй сэтгэл, оюуны нэгэн үйл болох зүүдийг харилцан адилгүй дүрслэн үзүүлсэн байна. Тодорхой зохиолын явдал бүхий аман яруу найргийн зүйл болох тууль, хүүрнэн өгүүлэх аман зохиолд багтах шидэт үлгэр болон түүх домогт зүүднээ үзсэн зүйл тэр даруй бодитжин биежих шидэт өгүүлэмж илэрч байна.

Дутуу хатуугаас сэрсэн төдийд гэтлэх уг өгүүлэмж нь Цагаан өвгөн, Балданлхам бурхан зэрэг шидэт туслагчийн тусламжтайгаар биелэх аж. Шидэт зүүдэнд ирэх эдгээр дүр нь хишиг буяныг даасан тэнгэр, аврал одуулсныг хамгаалах холбоо хамаарал бүхий дүрүүд юм.

Тухайн баатар зүүднээ эдгээр баатрыг үзсэнээр зүүд гэх хийсвэр байдал болон хүртэгдэх бодит байдлын хил хязгаарыг давж, зүүд болон бодит амьдралаа болох үйл явдлыг шалтгаан үрийн холбоогоор илэрхийлэх боломжтой болжээ.

Ном зүй

Эх хэрэглэгдэхүүн

Ерөөлт Ж., Лхам П. (эмх.). 2021. *Монголын Бурханы шашны аман түүх I*. Улаанбаатар.

Ерөөлт Ж. (эмх.). 2012. *Монголын Бурханы шашны аман түүх II*. Улаанбаатар.

Катуу Б. (эмх.). 2010. *Нэрт туульч С.Чойсүрэнгийн туульс*. Улаанбаатар.

Катуу Б. (эмх.). 2017. *Дөрвөд ардын аман зохиол*. Улаанбаатар.

Сампилдэндэв Х. (эмх.). 1999. *Монгол домгийн чуулган*. Улаанбаатар.

Цэрэнсодном Д. (эмх.). 1982. *Монгол ардын үлгэр*. Улаанбаатар.

Судалгааны бүтээл

Бадамхатан С. (эрх.). 2012. *Монгол улсын угсаатны зүй II (XIX-XX зууны зааг үе - Ойрадын угсаатны зүй)*. Улаанбаатар.

Баясгалан Ш. 2012. *Арван хангал бурхдын тахилга*. Улаанбаатар.

Дайриймаа Б. 2013. *Монгол ардын үлгэрийн баатруудын уран дүрслэлийн онцлог*. Улаанбаатар.

Дулам С. 2020. *Монгол бэлгэдэл зүй IV – Зүүд, зөн совингийн бэлгэдэл зүй; Цагийн бэлгэдэл зүй*. Улаанбаатар.

Дулам С. 2020. *Монгол домог зүйн дүр*, Улаанбаатар.

Мостаэрт А. 2011. *Ордос судлал*. Улаанбаатар.

Нандинбилиг Г., Дулам С. 2020. *Монгол аман зохиолын онол II (Хүүрнэн өгүүлэх аман зохиол, Жүжиг наадмын аман зохиол)*. Улаанбаатар.

Товчилсон нэр

ДАЗЧ – Дөрвөл аман зохиолын чуулган
МАҮ – Монгол ардын үлгэр
МБШАТ – Монголын Бурханы шашны аман түүх
МДЧ – Монгол домгийн чуулган
МУУЗ – Монгол улсын угсаатны зүй
НТЧТ – Нэрт туульч С.Чойсүрэнгийн туульс

Abstract

In Mongolian folklore, dreams, which is a reflection of a specific side of the human mind, are depicted in different ways. In this article, we have analyzed the motif of a magical dream and a hero who fills up the missing part of the story in a folktale and an epic, the category of verbal art. From this point of view, the deeds of the White Old Man and Palden Lhamo, who are the characters that lead the events in the dream, are bound to be fulfilled as soon as they wake up.